



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2014 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/21

Эрдэнэт

Сургалт зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр хавсралтын дагуу Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас зохион байгуулж буй ажлыг сурталчлах нийтэд хүргэх зорилгоор төвийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлч, сурвалжлагч нарыг оролцуулсан “Мэдээллийн ил тод байдлыг хангахад хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо” сэдэвт сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажилд шаардагдах 7276400 /Долоон сая хоёр зуун далан зургаан мянга дөрвөн зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 01 сарын 01-ны өдрийн 1/01 дугаар захирамжийн хавсралт



**“Мэдээллийн ил тод байдлыг хангахад хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо” сэдэвт сургалт зохион байгуулах зардлын тооцоо**

№	Зардлын нэр	Нийт үнэ
1	Сургалтад оролцох сэтгүүлчдийн унааны зардал / Шатахуун, Унааны зардал/	1.750.000
2	Сэтгүүлчдийг “Эрдэнэт” зочид буудалд байрлуулах зардал	754.000
3	“Мэдээллийн ил тод байдлыг хангахад хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо” бэлэг дурсгалын зүйлс	692.900
4	Цайны завсарлагааны зардал	1.088.113
5	Сэлэнгэ амралтын баазад байрлуулах зардал	2.871.400
6	Тамгын газраас ашиглах автомашины шатахууны зардал	120.000
	<b>Нийт</b>	<b>7.276.400</b>